



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 01/2912 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг 6 дугаар сарын 15, жилийн тайланг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Захиргаа удирдлагын газарт ирүүлж байхыг бүх газар, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000382



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2023 оны 01 дугаар сарын 05-ны
өдрийн 05 дугаар тушаалын хавсрагт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа	Хариуцах нэгж
1	Авлигын эсрэг тогтоомжийг сурталчлах, гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	<p>1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;</p> <p>1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлог тохируулан зохион байгуулах;</p> <p>1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;</p> <p>1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио</p>	<p>-Баримтжуулсан байх; -Үр дүнг тооцож, тайлагнасан байх (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо); -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа гэх мэт соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. -Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. -2-оос доошгүй сурталчилгааны</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p> <p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p> <p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p> <p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p> <p>Бүх газар, нэгж</p> <p>ЗУГ, МТХ</p> <p>ЗУГ, СБСА, ХМОНХА</p>

		<p>контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийгэд хүргэсэн байх;</p>	<p>материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийгэд хүргэсэн байх; -Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.</p>		
2	<p>Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах;</p>	<p>2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах;</p> <p>2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ гм) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;</p>	<p>-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэдлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p> <p>-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p> <p>Бүх газар, нэгж</p>

3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	<p>-Байгууллагын бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;</p> <p>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;</p> <p>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;</p> <p>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;</p> <p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ЗУГ, ХЭЗХ
3.2.	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх;		<p>-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;</p> <p>-Сургалт, мэдээлэл авсан байх;</p> <p>-Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.</p>	6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	Бүх газар, нэгж
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх гм);	<p>-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх;</p> <p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	Бүх газар, нэгж

	<p>4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;</p>	<p>-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p>
	<p>4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах;</p>	<p>-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p>
<p>5</p>	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх</p>	<p>-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; -Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p>
	<p>5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;</p>	<p>-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p>
	<p>5.3. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах;</p>	<p>-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khtmlbur.iias.mn цахим санд нэмж оруулсан байх; -Тайлагнасан байх.</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>ЗУГ</p>
	<p>5.4. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан хяналт</p>	<p>-Эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулсан байх.</p>	<p>6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>ХШЗГ МУГА</p>

	шалгалтын зорилгоор зохицуулалттай этгээд тус бүрийн салбартай холбоотой эрсдэлийг үнэлэх;			
5.5. Бага эрсдэлтэй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээс хэсэгчлэн чөлөөлөх боломжийг судлах;	-Судалгаа хийсэн байх.		6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ХШЗГ МУТА
5.6. Траст буюу ямар нэг этгээдийн хөрөнгийг удирдан, захиран зарцуулж ашиг олж өгч байгаа компани, үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх;	Эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэсэн байх.		6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ХШЗГ МУТА
5.7. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбогдох эрсдэл, хүлээх үүрэг хариуцлага, мэдээлэх үүргийг таниулах, ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх;	-Хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлсэн байх.		6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ХШЗГ МУТА
5.8. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нарийвчлан судалж, эрсдэлд суурилсан арга хэмжээг авах;	-Эрсдэлийг судалсан байх; -Арга хэмжээг авсан байна.		6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ХШЗГ МУТА
5.9. Виртуал хөрөнгийн салбарын NFT буюу койн, токены арилжааны платформуудын зохицуулалтын орчин, бодлогыг тодорхойлох;	-Зохицуулалтын орчин, бодлогыг тодорхойлсон байх.		6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ХШЗГ МУТА
5.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд бусад төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх;	-Төрийн байгууллагуудтай хамтран үр дүнтэй ажилласан байх.		6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ХШЗГ МУТА